



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 65

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 287,766,100 /хоёр зуун наян долоон сая долоон зуун жаран зургаан мянга нэг зуу/ төгрөгийн балансын үнэтэй, 227,581,612,75 /хоёр зуун хорин долоон сая таван зуун наян нэгэн мянга зургаан зуун арван хоёр төгрөг далан таван мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй нийт 6 нэр төрлийн хөрөнгийг хавсралтын дагуу Луус сумын Засаг даргын Тамгын газар, Ахмадын хороо, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрт тус тус балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), Луус сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ганчимэг), Ахмадын хорооны дарга (Ц.Сугир), Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын дарга (А.Ууганбаяр) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
65 дугаар тогтоолын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага	
1	Проектор	2018он	ширхэг	1.00	1,700,000	1,700,000	1,614,999.81	85,000.19	Ахмадын хороо	
2	Трактор	2022он	ширхэг	1	46,700,000	46,700,000	3,502,500.03	43,197,499.97	Луус ЗДТГ	
3	Анжис	2022он	ширхэг	1	3,250,000	3,250,000	243,749.97	3,006,250.03	Луус ЗДТГ	
4	Гэрэлтүүлэг тогтоох краказ тоног төхөөрөмж	2022он	ширхэг	1	42,000,090	42,000,090	14,000,030.04	28,000,059.96	Тэнгэрийн тэмдэг	
5	Цахилгаан шийт, иж бүрдэл (гэрэл, хөгжим, лед)	2022он	ширхэг	1	15,000,040	15,000,040	5,000,013.36	10,000,026.64	Тэнгэрийн тэмдэг	
6	Брэнд: Eagar Led Модел: P3.91-OR16S-SMD1921-64x64-L500xH1000-1000E Барааны нэр: Зөврийн Лед дэлгэц	2022он	ширхэг	1	179,115,970	179,115,970	35,823,194.04	143,292,775.96	Тэнгэрийн тэмдэг	
							287,766,100.00	60,184,487.25	227,581,612.75	

ДҮН